УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМ ХЭЗЭЭ ҮҮССЭН БЭ?

- Түүхэн үүднээс намын үүслийг XVII зууны сүүл XVIII зууны эхэн үед хамааруулдаг.
- Энэ үед Европ, Америкт засаглалын шинэ харилцаа бүхий улс төрийн тогтолцоо үүсч эхэлжээ.
- Франц, Английн хувьсгалууд, АНУ-ыг байгуулах зэвсэгт тэмцэл зэрэг нь төрийн шинэ хэлбэр тогтох үйл явцын онцлогийг тод харуулсан хийгээд энэхүү тэмцлийн дотор олон янзын урсгалыг төлөөлсөн намууд үүсэн тогтсон байна.



УЛС ТӨРИЙН НАМ

- ЯЗГУУРТНЫ БҮЛЭГЛЭЛ
- УЛС ТӨРИЙН КЛУБ
- ОРЧИН ҮЕИЙН НАМ

Улс төрийн нам нь улс орны хөгжлийг хамтын зарчмаар тодорхойлж, хэрэгжүүлж, улс төрийн хамтын хариуцлага хүлээх чадвартай иргэдийн эвлэлдэн нэгдсэн чөлөөт бүтэцтэй байгууллага юм.

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМ НИЙГЭМД ЯМАР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭДЭГ ВЭ?

- Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх
- Улс төрчдийг бэлтгэж, чадваржуулж, нэр дэвшүүлэх
- Бодлогын хэрэгжилтээ тайлагнах, хариуцлага хүлээх
- Намын дотоод ардчиллыг хангах
- Иргэдийн оролцоог хангах

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМ ХЭРХЭН БАЙГУУЛАХ ВЭ?

8.1.Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид “үүсгэн байгуулах хурал” гэх/-аар үүсгэн байгуулна.

8.2.Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна.

8.3.Намыг үүсгэн байгуулах хуралд орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулна.

8.4.Намыг үүсгэн байгуулах хурлаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

8.4.1.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбааны загварыг батлах;

8.4.2.намын мөрийн хөтөлбөр, дүрмийг батлах;

8.4.3.намын удирдах болон хяналтын байгууллагыг сонгон байгуулах, түүний зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийг тогтоох;

8.4.4.нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.

8.5.Намыг үүсгэн байгуулах хурлаас нам үүсгэн байгуулсан тухай шийдвэр гарсан өдрийг тухайн нам үүсэн байгуулагдсан өдөрт тооцох бөгөөд энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ.

8.6.Нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээсээ хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болох бөгөөд энэ заалт өөрчлөн байгуулагдаж шинээр бүртгүүлсэн намуудад хамаарахгүй.

/Энэ хэсгийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

8.7.Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад аливаа байгууллага, албан тушаалтны зүгээс дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМ ХЭРХЭН БАЙГУУЛАХ ВЭ?

9.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн1 14.1-д заасны дагуу тухайн нам үүсгэн байгуулагдсан өдрөөсөө хойш ажлын 10 хоногт багтаан бүртгэх байгууллагаас баталсан маягтын дагуу бүртгүүлэх өргөдлөө Улсын дээд шүүхэд гаргана.

9.3.1.намыг бүртгүүлэхийг хүссэн намын даргын гарын үсэг бүхий өргөдөл;
9.3.2.намын нэр, бэлгэдэл, далбаа;
9.3.3.намын дүрэм;
9.3.4.намын мөрийн хөтөлбөр;
9.3.5.намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг;

9.3.7.намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/;

9.4.Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш энэ хуулийн 6; 9.2- 9.3-т заасан зүйлийг нягтлан үзэж, ажлын 30 хоногийн дотор тухайн намыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох бөгөөд энэ тухай нийтэд мэдээлнэ.

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮН, ДЭМЖИГЧ ГЭЖ ХЭН БЭ

- НАМЫН ГИШҮҮН нь хувийн болон улс төрийн байр сууриндаа тулгуурлан улс төрийн намын үнэт зүйл, үзэл суртлыг зөвшөөрч намд элссэн хувь хүнийг хэлдэг.

- ДЭМЖИГЧ нь намын үзэл суртлыг зөвшөөрч сонгуулийн үед намын мөрийн хөтөлбөрийн төлөө саналаа өгдөг чөлөөт иргэн бөгөөд нам доторх бүлгүүд болон зохион байгуулалтаас гадна байдаг.

Нэг намын тогтолцоо

- Зөвхөн нэг нам дангаар ноёрхож, төрийн эрх мэдлийг барих ба бусад нам хөдөлгөөнийг хориглодог.
- ЗХУ тэргүүтэй социалист орнууд болон 1921-1924 он хүртэлх БНМАУ

Хоёр намын тогтолцоо

- Засгийн эрх мэдлийг хүлээн авч хэрэгжүүлэх чадвартай хоёр нам давамгайлдаг, сонгуульд нэг нам нь ялахад нөгөө нь сөрөг хүчин болдог
- АНУ, Их Британи

Олон намын тогтолцоо

- Улс төрийн амьдралд хэд хэдэн нам идэвхтэй оролцож, засгийн эрх мэдлийн төлөө өрсөлдөж байдаг.
- 1990 онд МУ олон намын тогтолцоонд шилжсэн

УЛС ТӨРИЙН НАМ

Олон намтай байхын ач холбогдол

- Олонхийн дэмжлэг авсан нам засаглалыг хэрэгжүүлдэг
- Цөөнхийн дэмжлэг авсан нам нь эрх баригч намыг хянаж ажилладаг
- Нэг нам ноёрхох боломжийг хязгаарладаг
- Засаглалын тэнцвэр хадгалах нөхцлийг бүрдүүлдэг
- Олон ургальч үзлийг дэмждэг
- Хүний эрхийг хангадаг

Улс төрийн намд хүлээлгэх хариуцлага

- Мөнгөн торгууль буюу захиргааны арга хэмжээ авах
- Эрүүгийн хариуцлага (хууль зөрчсөн тохиолдолд)
- Улс төрийхн хариуцлага хүлээлгэх

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМЫН ЧИГ БАРИМЖАА

Тэгвэл **зүүний** гэх үзэл баримтлал нь нийгмийн эрх тэгш байдлыг хангаж, доод давхаргын амьдралыг дээшлүүлэхэд чиглэдэг. Ингэхдээ аж үйлдвэр, үйлчилгээг нийгэмчлэх, төрийн эрх мэдлийг багасгах эсвэл хязгаарлахыг дэмжихээс гадна нийгмийн гарал үүсэл, хүйс, яс үндсээр нь ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого баримталдаг ажээ. Уг үзэлд анархизм, коммунизм, социализм, сонгодог либерализм, социал-демократ үзэл багтана.

•Хүнийг ялгаварлан гадуурхах явдлыг тэвчих
•Баян, хоосны ялгааг арилгах
•Олон ургальч байдал, олон тулгуурт төрийн зохицуулалтыг бий болгох
•Жижиг, дунд үйлдвэрийг дэмжиж, эдийн засгийн эрх тэгш байдлыг чухалчлах
•Хөдөлмөрийн хөлс, ажлын байрны нөхцөлийг дээшлүүлж, ажилгүйдлийг багасгах
•Бүх нийтийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэврийн нэгдсэн үнэ төлбөргүй тогтолцоо бий болгож, нийгмийн эмзэг давхаргад төр, олон нийтийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг чиглүүлэх
•Хүн амын орлогын төлөвт нийцүүлж уян хатан татварын бодлого явуулах зэрэг болно.

УЛС ТӨРИЙН НАМ

УЛС ТӨРИЙН НАМЫН ЧИГ БАРИМЖАА

Барууны үзэл баримтлал нь анхандаа хаант засаглал, уламжлалт удирдлагын хэлбэрийг илүү төлөөлдөг байсан бол яваандаа чөлөөт зах зээлийн эдийн засгийн үзэл санааг дэлгэрүүлэх болсон билээ.

•Хүн ам, цагаачлалын чиглэлд хатуу бодлого баримтлах
•Байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх бодлого баримтлах
•Язгуур хэл, соёл, уламжлалаа хадгалах, хамгаалах
•Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх
•Нийгмийн ёс суртахууныг хангах, хадгалах
•Сүсэг бишрэл, үнэт зүйлээ дээдлэх
•Төрийн эрх мэдлийг хариуцлагатай болгох
•Ардчилал, хүн төрөлхтний эв санааны нэгдлийг хангах зэрэг болно.

🤔🤔🤔

УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААР ТА ХЭР САЙН МЭДЭХ ВЭ?

🐄🐄➡️🏛️
🙋‍♂️🙋‍♂️🙋‍♀️🙋‍♀️↩️

СОЦИАЛИЗМ

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ.

ТӨРӨӨС ТАНЫ ҮНЭЭГ БУСАД АЙЛЫН ҮХРҮҮДТЭЙ НИЙЛҮҮЛЭН, НИЙТИЙН ӨМЧ БОЛГОЖ, ДАРАА НЬ СҮҮГ НЬ ТАРААНА.

🐄🐄➡️🏛️
🏠❤️🏠↩️

КОММУНИЗМ

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ.

ХОЁР ҮНЭЭГЭЭ ТӨРД ӨГЧ НИЙТИЙН ӨМЧ БОЛГОНО. ТАНАЙ ХӨРШҮҮД ХАМТДАА ӨСГӨН ТЭЖЭЭЖ, СҮҮГЭЭ ХУВААН АВНА.

🐄🐄➡️🏛️
🥛💰🥛💰↩️

ФАШИЗМ

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ.

ХОЁР ҮНЭЭГЭЭ ТӨРД ӨГЧ, ТЭД СҮҮГ НЬ ЭРГҮҮЛЭЭД ТАНД ЗАРНА.

🐄💰➡️🐂
🤗🐄🐂↩️

КАПИТАЛИЗМ

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ.

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ. ТА НЭГИЙГ ЗАРААД, БУХ ХУДАЛДАН АВЧ БОЛНО.

🐄🐄🤔🥛🥛

АРДЧИЛАЛ

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ.

ТА ХОЁР ҮНЭЭТЭЙ. ТА СҮҮГ НЬ ЗАРЖ БОЛНО. ЭСВЭЛ ҮНЭЭГЭЭ ӨСГӨН ҮРЖҮҮЛЖ БОЛНО.

А- 35. Ямар шалгуурыг үндэслэн улс төрийн намуудыг нэг намын, хоёр намын, олон намын тогтолцоотой гэж ангилдаг вэ?

A. Баримталж буй үзэл суртлын агуулгаар нь

B. Эрх мэдлийг хэрэгжүүлж буй байдлаар нь

C. Улс төрийн байр сууриар нь

D. Үүргийн шинж чанараар нь

E. Зохион байгуулалт ба үйл ажиллагааных нь шинж чанараар

В-35. Олон намын тогтолцооны ач холбогдлыг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ?

A. Бусад нам хөдөлгөөнийг хориглодог

B. Нэг нам ноёрхох боломжийг хязгаарладаг

C. Засаглалын тэнцвэрийг хадгалах нөхцөл бүрддэг

D. Олон ургальч үзлийг дэмждэг

E. Хүний эрхийг хангадаг

С-35. Улс төрийн намыг ямар шалгуурыг үндэслэн эрх баригч нам, сөрөг нам гэж ангилдаг вэ?

A. Зохион байгуулалт ба үйл ажиллагаагаар нь

B. Улс төрийн тогтолцоо /систем/-д эзэлж буй байр сууриар нь

C. Улс төрийн чиг баримжаагаар нь

D. Үзэл суртал агуулгаар нь

E. Үйл ажиллагааны шинж чанараар нь